# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
# ТОГТООЛ

2021 оны 01 сарын 12 өдөр Дугаар 10 Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 , аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1,313,500 /нэг сая гурван зуун арван гурван мянга таван зуу/ төгрөгийн балансын үнэтэй, 283,500.08 /хоёр зуун наян гурван мянга таван зуун төгрөг тэг найман мөнгө/-ний үлдэгдэл өртөгтэй 5 нэр төрлийн 37 ширхэг хавсралтад дурдсан хөрөнгийг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрийн дарга (А.Ууганбаяр)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор акталж устган данснаас хассаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх.

2.1 Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын
12-ний өдрийн 10. тогтоолын хавсралт

Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын актлах хөрөнгийн мэдээлэл

| д/д | Хөрөнгийн нэр | Ашиглалтанд орсон огноо | хэмжих | тоо хэмжээ | нэгжийн үнэ | Балансын үнэ | Хуримтлагд сан элэгдэл | Үлдэгдэл өртөг | Данснаас хасах болсон шалтгаан | Актлах төрөл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Үндсэн хөрөнгийн данс : Тавилга эд хогшил | | | | | | | | | |
| 1 | Пивор жижиг сандал /хятад/ | 2014.11.17 | ш | 15 | 8500 | 127500 | 127500 | 0 | Дугуйлангийн хүүхдүүдийн тоглолт сургалтад хэрэглэж байсан эвдэрч хэмхэрсэн цаашид ашиглах ,засварлах боломжгүй | актлах |
| 2 | Шүүгээ | 2018.12.31 | ш | 2 | 30000 | 60000 | 60000 | 0 | Багш нарын шүүгээ ашиглалтын явцад эвдэрсэн цаашид засварлахгүй болсон | актлах |
| | Дүн | | | 17 | | 187,500 | 187,500 | 0 | | |
| | Үндсэн хөрөнгийн данс : Машин тоног төхөөрөмж | | | | | | | | | |
| 3 | Спикер цо /хятад/ | 2017.12.26 | ш | 1 | 170000 | 170000 | 169999.92 | 0.08 | Бүжгийн дугуйлангийн хүүхдүүдийн тоглолт ,сургалтанд хэрэглэж байсан эвдэрч шатсан цаашид ашиглах ,засварлах боломжгүй | актлах |
| 4 | Lamp 300w | 2015.12.31 | ш | 18 | 42000 | 756000 | 472500 | 283500 | Тайзны нэмэлт лампа 300w цахилгааны хэлбэлзэлээс | актлах |

11

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | шатсан . Ашиглалтгүй болсон | |
| 5 | Дэлгэцтэй өсгөгч , спикер /хар / /хятад/ | 2017.12.26 | ш | 1 | 200000 | 200000 | 200000 | 0 | Ашиглалтын хугацаа дууссан. Циркийн дугуйланд хэрэглэж байсан .шатаж эвдэрсэн . | актлах |
| Дүн | | | | 20 | | 1,126,000 | 842499.92 | 283500.08 | | |
| Нийт | | | | 37 | | 1,313,500 | 1,029,999.92 | 283,500.08 | | |

12